



Бүлэг: 4 “ Хүний эрх ба хууль”

Сэдэв: Хүний эрхийн зөрчил
түүний үр дагавар

Хамрах хүрээ: 9 анги

УЛААНБААТАР
2021

Багш: З.Цэвэгмиджав



Хүний эрхийн зөрчил, түүний үр дагавар

Бид өмнөх хичээлээрээ төр нь хүний эрхийг хамгаалдаг, ардчилсан иргэн байх нь эрхээ эдлэхийн хамт үүргээ биелүүлдэг байх шаардлагатай тухай үзсэн. Өөрөөр хэлбэл хүний эрхийн талаар мэдлэгтэй хүн эрхээ эдэлж зөрчигдсөн тохиолдолд түүнийгээ хамгаалж хууль ёсны байгууллагад хандаж сэргээх боломжтой байдаг төдийгүй эрхээ мэддэг хүн бусдын эрхийг хүндэтгэдэг, үүргээ биелүүлдэг байна.

Үүнээс харахад хүний эрхийн зөрчлийн суурь шалтгаан нь

1

Хүмүүсийн хүний эрхийн тухай ойлголт, мэдлэг дутмаг байгаа байдал

2

Нөгөө талаас хүний эрхийг хамгаалахтай холбогдох төр түүний албан байгууллага, албан тушаалтаны хариуцлага, мэдлэг мэдээлэлгүй байдалтай холбоотой юм.

хүний эрхийн зөрчлүүд үүсч байна.



Мөн тухайн улс орны эдийн засаг, нийгэм улс төрийн байдал нь хүний эрхийн хэрэгжилтэнд нөлөөлнө. Тухайлбал аливаа ард түмэн нь дарангуйлал, боолчлолд өртсөн тохиолдолд улс орны хөгжил удааширч, ард түмэн нь эрх эрх чөлөөгөө эдлэх боломжгүй байдаг байна. Үүнийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг жишээ болгон авч үзэж тайлбарлая.

Тэгвэл: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө гэж юуг хэлэх вэ?



Эвлэлдэн

нэгдэх, жагсаал цуглаан хийх, сонгох зэрэг бусад олон эрх, эрх чөлөөтэй огтлолцож байдаг.



Мөн боловсрол эзэмших, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн хангамж хүртэх, хөдөлмөрлөх эрх зэрэг нийгэм соёлын эрхийн хэрэгжилтэд ч нөлөөлдөг.



Шудрага

шүүхээр шүүлгэх, төр улсын хэрэгт оролцох зэрэг иргэний болон улс төрийн бусад эрх, эрх чөлөөгөө эдлэхэд чухал үүрэгтэй.



Эдгээр шинжийг агуулна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь дараах арга, хэлбэрээр илэрдэг. Үүнд:


- Үг хэлэх
- Бичгээр буюу хэвлэн нийтлэх
- Урлаг, Уран сайхны хэлбэрээр
- Тайван жагсаал цуглаан хийх гэх мэт





Хамгийн гол нь: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгмийн үндэс суурь бөгөөд нийгмийн дэвшил, хувь хүн бүрийн хөгжлийн гол нөхцөлийг бүрдүүлэгч чухал хүчин зүйл юм.

Гэвч өнөөдөр энэхүү эрх, эрх чөлөө зөрчигдсөөр байгааг олон эх сурвалжаас харж болно. Сурах бичгийн хуудас:72- уншина уу.



Мөн төр засаг хариуцлагатай ил тод байхад хэвлэл
мэдээлэл чухал үүрэгтэй.



Хэвлэл мэдээлэл нь нийгэмд болж буй үйл явдал, мэдэгдэл бодлого, саналыг ажиглах, баримтжуулах, тайлбарлан дүрслэх, шүүмжлэх замаар иргэдэд хүргэдэг

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь дараах үүрэг
гүйцэтгэдэг.



- Мэдээлэл олгох,
- Иргэдийн санаа бодол төлөвшүүлэхэд туслах,
- Хяналт тавих, шүүмжлэл өрнүүлэх,
- Цэнгээн баясгах, боловсрол олгох зэрэг болно.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл аль болох бүрэн, үнэн зөв, бодитой, ойлгомжтой байдлаар мэдээллээ хүргэх хэрэгтэй.




Ингэснээр ард түмэн нийгэмд болж байгаа бүхий л үйл явдалтай танилцаж, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, байр сууриа илэрхийлэх боломжтой болдог. Энэ нь эргээд хүний эрхийн зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх боломжыг олгодог байна.

THANKS!



Хуульчүүд Хүний эрх ба хууль бүлэг сэдэвтэй холбоотой зарим нэр томъёоны тайлбарыг хавсаргав.

Нэр томъёоны тайлбар



□ **Хууль:** Төрөөс тогтоосон заавал биелүүлэх хэм хэмжээний цогц

Хууль ёсны эрх: Хуулиар тодорхойлж, шүүхээр хамгаалсан эрх
Хүний эрх: Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн шудрага ёсны зарчим, хүйс, арьс өнгө, гарал үүсэл, нас, анги дадхрага, шашин болон улс төрийн итгэл үнэмшилээс үл хамааран бүх хүний адил тэгш эдлэх нийтлэг эрх

Хүний эрх: Хүн бүрт олгогдож буй боломж юм.

Үндсэн хууль: Засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй, хамгийн дээд хүчин чадалтай, засаг, төрийн гол хууль юм.

Хүний эрхийн зөрчил” гэж Үндсэн хууль болон бүс нутгийн, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр, засгийн байгууллагууд зөрчсөн, төрөөс хамааралтай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тэдгээр эрх зүйн хэм хэмжээнээс урган гарах хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ.